



**ДУНДГОВЬ АЙМГИЙН  
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 02 сарын 10 өдөр

Дугаар A/17

Мандалговь

“Оюуны гэгээ” төрийн бус байгууллагатай  
хүүхэд хамгааллын хариу үйлчилгээний  
гэрээ байгуулах тухай

Хүүхэд хамгааллын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2, 18 дугаар зүйлийн 18.2.4, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл 16.5.5, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2016 оны 12 сарын 26-ны өдрийн А/330 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээг үзүүлэх хуулийн этгээдийг магадлан итгэмжлэх журам”-ын 5.2 дахь заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Гэр бүл, хүүхдэд нийгмийн ажлын болон “Хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ” үзүүлэх гэрээг магадлан итгэмжлэгдсэн “Оюуны гэгээ” төрийн бус байгууллагатай 2020 оны 02 дугаар сараас 10 дугаар сар хүртэлх хугацаагаар байгуулж, зардал олгосугай.

2. Үйл ажиллагаанд хяналт тавьж ажиллах ажлын хэсгийг 1 дүгээр, төсвийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Шаардагдах зардалд 8 000 000 (Найман сая) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. “Оюуны гэгээ” төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд арга зүйн дэмжлэг үзүүлэн, хяналт тавьж ажиллахыг Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 10 дугаар сарын 25-ны өдрийн дотор Даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг Хүүхэд хамгаалал, залуучуудын асуудал хариуцсан мэргэжилтэн, ажлын хэсгийн ахлагч (Ш.Эрдэнэсүвд)-д даалгасугай.

ДАРГА



Ц. ГАНЗОРИГ

481190033